

ТӨВИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙГДСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

2025 оны 12 дугаар сарын 23-ны өдөр.

Үнэлгээний зорилго

Төвийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, хүрсэн түвшинг тогтоох, гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хариуцлагыг сайжруулах, удирдлагыг бодит мэдээллээр хангахад оршино.

Үнэлгээний арга зүй.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны “Аргачилал заавар батлах тухай” 100 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 07 сарын 01-ий А/346 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ” хийх нийтлэг журмыг тус тус үндэслэн төвийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.

Хяналт - шинжилгээ, үнэлгээ

Төв нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний маягтын дагуу 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, Эрүүл мэндийн сайдаар батлуулсан. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 61 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

1. Эрүүл мэндийн сайдаас тусгайлан үүрэг болгосон 8 арга хэмжээ;
2. Шинээр төлөвлөсөн 10 арга хэмжээ;
3. 2024 оноос үргэлжлүүлэн хэрэгжүүлж буй 19 арга хэмжээ;
4. Тогтмол зохион байгуулдаг 24 арга хэмжээ багтаж байна.

1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээ

Хүснэгт 1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2025 оны хэрэгжилтийн үнэлгээний дүн

№	Байгууллага	Зорилтын тоо	2025 онд Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн үнэлгээ						Дундаж хувь
				100	90	70	50	30	0.0	
1.	ЦССҮТ-ийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө	4	61	53	5	3	-	-	-	97.7%

Хүснэгт 2. Хэрэгжилт сул, 70%-иас доош үнэлгээтэй арга хэмжээ

№	Заалтын дугаар	Хэрэгжүүлэх арга хэмжээ, хэрэгжилтийн хувь	2025 оны хүрэх түвшин	Тайлбар
Зорилт 1. Эрүүл мэндийн сайдаас тусгайлан үүрэг болгосон арга хэмжээг бүрэн хэрэгжүүлнэ.				
1.	2.	Цус цуглуулах суурин төв шинээр байгуулна. (70%)	Сонгинохайрхан, Хан-уул дүүргээс сонгон, цус цуглуулах суурин төв шинээр нээж, үйл ажиллагааг нь эхлүүлсэн байна.	Цус цуглуулах суурин төв шинээр байгуулахад шаардлагатай өрөө, талбайн хэмжээг тооцож БГД-ийн ИТХ, ЗДТГ, ТЗНЭ-үүдэд байрны дэмжлэг үзүүлэх албан тоот хүргүүлж уулзалт хийсэн. ТЗНЭ-ийн удирдлага өрөө санал болгож, Хотын баруун талд БГД, ХУД, СХД-үүдэд зам дагуу, автобус нийтийн унаанд ойр, автомашины зогсоол хүртээмжтэй байх, нийтийн худалдаа, нэг цэгийн үйлчилгээтэй ойр зэрэг нийтлэг шалгуурыг хангасан байхаар газарт шийдвэрлүүлэх дэмжлэг хүссэн. БГД-ийн ИТХ судлаад дэмжиж, хамтарч ажиллахаар урьдчилсан байдлаар тохирсон. Төрийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийг оновчтой болгох, удирдах, гүйцэтгэх албан тушаалын зохистой харьцааг бүрдүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, захиргааны нүсэр бүтцийг багасгаж ажиллах тухай ЭМС-ын 2025 оны 06 сарын 25-ний өдрийн 1а/3266, 2025 оны 07 сарын 22-ны өдрийн 1а/3546 албан албан бичгийн хэрэгжилтийн хүрээнд 2025 онд шинэ төв байгуулах төлөвлөгөөт ажлыг түр хойшлуулсан.
Зорилт 1.2.1. Цахим мэдээллийн сан бүрдүүлж, аюулгүй байдлыг хангана.				


2.	24	“Цусны донор” аппликейшны хөгжүүлэлт хийж, үйл ажиллагааг тогтмолжуулна. (70%)	Ажлын даалгаврын дагуу загвар, функцүүдэд шаардлагатай засварыг хийж, “Цусны донор” аппликейшны байнгын ажиллагааг хангаж ажилласан байна.	2025.01.23 өдөр АУГ/25-03 дугаартай ажил гүйцэтгэх гэрээ программ хөгжүүлэгчтэй хийгдсэн. Гэрээний ажлын даалгаварт орсон засаж сайжруулах ажил хийгдэж, 2025 оны 11 сард тест хувилбар, хөгжүүлэлтийн эрх хүлээн авч, сайжруулалт хийж байна.
Зорилт 1.4.2. Цус, цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хадгалалт, олголтод технологийн шинэчлэл хийнэ.				
3.	30	БСТЗ 1.4.2 Цус цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэлд бүхэл цус боловсруулах үйлдвэрлэлийн процессыг бүрэн автоматжуулсан платформ (Reveos® Automated Blood Processing System)-ыг нэвтрүүлнэ. (70%)	“Бүхэл цус боловсруулах үйлдвэрлэлийн процессыг бүрэн автоматжуулсан платформ”-ыг цус цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэлд нэвтрүүлсэн байна. Ажилтнуудыг сургалтад хамруулсан байна.	Цус, цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэлд бүхэл цус боловсруулах үйлдвэрлэлийн процессыг бүрэн автоматжуулсан платформ нэвтрүүлэхээр төвийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусган ЦССҮТ/2025202010 тендер шалгаруулалтын дугаартай “Эмнэлгийн тоног төхөөрөмж, аппарат” тендерт 682,500,000 төгрөгийн үнэ бүхий Багц №2: “Бүхэл цус боловсруулах автомат аппарат /цус, цусан бүтээгдэхүүний бүрэн автомат технологи/ тендерийг 2025 оны 02 сарын 26-ны өдөр зарлаж, 2025 оны 04 сарын 09-ний өдөр нээсэн. Космос тек монгол ХХК нь гүйцэтгэгчээр шалгарсан ба 2025 оны 04 сарын 17-ний өдөр шалгарсан оролцогчдод гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэж, үр дүнг цахим системд нийтэлсэн. 2025 оны 04 сарын 28-ний өдөр “Космос тек монгол” ХХК-аас Багц №2 буюу Цус, цусан бүтээгдэхүүний бүрэн автомат технологийн үйлдвэрлэгч нь 2025 онд манай улсад нийлүүлэх боломжгүй байгаа тул дээрх тоног төхөөрөмжийг нийлүүлэх боломжгүй болсон тухай 81 тоот албан бичгээр мэдэгдсэн.

Дүгнэлт

1. Төвийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлагдсан загварын дагуу боловсруулж ЭМЯ, төрийн захиргааны удирдлагын газраас аргагүйн зөвлөгөө авч, бодлогын баримт бичигтэй уялдуулан, зорилт, шалгуур үзүүлэлтийг тодорхойлж хугацаанд нь батлуулж, хэрэгжүүлж ажилласан;
2. Төвийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2025 оны хэрэгжилтэд үнэлгээ хийхэд 100% биелэлттэй 53 ажил, 90%-ийн биелэлттэй 5 ажил, 70% биелэлтэй 3 ажил байна.
3. Хяналт шинжилгээ, үнэлгээгээр төвийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны биелэлт 97.7%-тай байна.

Цаашид авах арга хэмжээ.

1. Төвийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2025 оны хэрэгжилтийн биелэлтэд хийсэн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн, танилцуулгыг Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, гарсан зөвлөмж шийдвэрийг хэрэгжүүлэх

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН: ЦЧАБА-НЫ ДАРГА  Э.ТУНГАЛАГТУЯА